



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/123

Чингис хот

Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хаах,
зарим хязгаарлалтын арга хэмжээг авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 05 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 09 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирус /covid19/ илэрсэнтэй холбогдуулан орон нутагт зорчигч тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 03 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл бүрэн зогсоосугай.

2. Халдвараас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга Цагдаагийн хурандаа Б.Батсайхан, Авто тээврийн төвийн дарга Б.Ганбат, Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ, Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа Н.Чанцал, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундааг худалдан борлуулах түүгээр үйлчлэх үйл ажиллагааг дээрх хугацаанд зогсоосугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хорио цээрийн хязгаарлалтын дэглэмийг мөрдөн онцын шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй, холбогдох төрийн байгууллагын тавьсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж олон нийтийн газраар зорчихгүй байхыг иргэдэд уриалсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Шуурхай штабын дарга дэд хурандаа Н.Чанцал нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА